

2013 ОНЫ 12 ДУГААР САРЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2013 оны 12 дугаар сарын гүйцэтгэлийн мэдээгээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын бүрдүүлэлт 92.1 хувийн, нийт зарлага 90.8 хувийн гүйцэтгэлтэй, төсвийн нийт тэнцэл 297.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, төлөвлөсөн дүнтэй харьцуулахад 119.5 тэрбум төгрөгөөр бага байна.

Монгол Улсын төсвийн 2012 оны хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 43.1.2-т заасны дагуу энэ оны 3 дугаар сарын 31-нийг хүртэл нийт 190.9 тэрбум төгрөгийг зарцуулан 2012 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмж тусгасан болно.

Нэгдсэн төсвийн орлого, зарлагын байдлыг авч үзвэл:

A. Нэгдсэн төсвийн орлогын бүрдүүлэлт:

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2013 оны 12 дугаар сарын гүйцэтгэлээр 5,880.7 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 7.9 хувиар буюу 503.4 тэрбум төгрөгөөр дутуу биелж, өмнөх оны мөн үеийнхээс 14.8 хувиар буюу 1,017.6 тэрбум төгрөгөөр илүү байна.

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг орлогын төрлөөр авч үзвэл:

ТӨСВИЙН ОРЛОГО	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны мөн үеийг	жилийн Төлөв.	2013 ОНЫ 12 САР Төлөв.	2013 ОНЫ 12 САР Гүйцэт.	Х У В Ъ (4 : 3)	ЗӨРҮҮ (4 : 2)	ЗӨРҮҮ (4 - 3)
	1	2	3	4	5	6	7
	(Тэрбум төгрөг)						
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,957.8	6,433.1	6,433.1	5,927.6	92.1	92.1	-505.5
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	94.7	49.0	49.0	46.9	95.7	95.7	-2.1
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖ	4,863.1	6,384.1	6,384.1	5,880.7	92.1	92.1	-503.4
УРСГАЛ ОРЛОГО	4,828.0	6,381.4	6,381.4	5,879.0	92.1	92.1	-502.4
ТАТВАРЫН ОРЛОГО	4,179.3	5,678.5	5,678.5	5,057.3	89.1	89.1	-621.2
Орлогын албан татвар	871.4	1,302.8	1,302.8	1,108.2	85.1	85.1	-194.5
ААН-ийн орлогын албан татвар	524.3	863.8	863.8	659.5	76.4	76.4	-204.2
Хувь хүний орлогын албан татвар	347.0	439.0	439.0	448.7	102.2	102.2	9.7
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	650.2	823.9	823.9	861.0	104.5	104.5	37.0
Өмчийн татвар	21.9	35.8	35.8	44.0	123.1	123.1	8.3
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	1,642.8	2,256.1	2,256.1	1,919.0	85.1	85.1	-337.2
Гадаад худалдааны орлого	327.4	516.6	516.6	381.4	73.8	73.8	-135.2
Бусад татвар	665.6	743.3	743.3	743.7	100.1	100.1	0.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	648.7	702.9	702.9	821.7	0.0	0.0	118.8
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	10.4	2.7	2.7	1.7	0.0	0.0	-1.0
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	24.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого татварын орлогоор 86.0 хувь, татварын бус орлогоор 14.0 хувь тус тус бүрдсэн үзүүлэлттэй байна. Эхний 12 сарын байдлаар Тогтворжуулалтын санд 46.9 тэрбум төгрөгийг улсын төсвөөс төвлөрүүлээд байна.

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг төсвийн бүрэлдэхүүнээр харуулбал:

ТӨСВИЙН ОРЛОГО	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		ХХС		НДС	
	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ
	(Тэрбум.төгрөг)							
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,606.4	4,032.1	1,874.2	1,882.0	397.6	392.7	1,240.1	1,270.5
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	49.0	46.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖ	4,557.5	3,985.3	1,874.2	1,882.0	397.6	392.7	1,240.1	1,270.5
УРСГАЛ ОРЛОГО	4,443.0	3,871.6	716.9	753.8	397.6	392.7	971.5	1,006.0
ТАТВАРЫН ОРЛОГО	3,871.3	3,194.2	654.1	678.0	329.3	324.1	971.5	1,006.0
Орлогын албан татвар	863.8	659.5	439.0	448.7	0.0	0.0	0.0	0.0
ААН-ийн орлогын албан татвар	863.8	659.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хувь хүний орлогын албан татвар	0.0	0.0	439.0	448.7	0.0	0.0	0.0	0.0
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн а/татвар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	971.5	1,006.0
Өмчийн татвар	0.0	0.0	35.8	44.0	0.0	0.0	0.0	0.0
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	2,231.2	1,893.2	24.9	25.8	0.0	0.0	0.0	0.0
Гадаад худалдааны орлого	516.6	381.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар	259.7	260.1	154.4	159.5	329.3	324.1	0.0	0.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	571.8	677.4	62.8	75.7	68.3	68.6	0.0	0.0
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	0.0	0.0	2.7	1.7	0.0	0.0	0.0	0.0
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	114.4	113.7	1,154.6	1,126.5	0.0	0.0	268.6	264.6

- Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 3,985.3 тэрбум төгрөгт хүрч 12.6 хувиар буюу 572.2 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 204.2 тэрбум, дотоодын бараа үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 150.7 тэрбум, импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 181.5 тэрбум, импортын барааны гаалийн албан татварын орлого 135.2 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс дутуу төвлөрсөн байна. НӨАТ-ын буцаан олголтоор 76.5 тэрбум төгрөг олгосон байна.
- Орон нутгийн төсвийн орлого 1,881.9 тэрбум төгрөгт хүрч, 0.4 хувиар буюу 7.7 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс давж биелсэн байна. Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлтийг зарим аймгуудаар дэлгэрүүлбэл, Нийслэлийн үйл ажиллагааны орлогын албан татварын орлого 1.7 тэрбум, хөрөнгө борлуулсны орлогын албан татварын орлого 5.3 тэрбум, бусад орлогын албан татварын орлого 4.3 тэрбум, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 1.6 тэрбум, газрын төлбөрийн орлого 4.4 тэрбум, хүү торгуулийн орлого 4.5 тэрбум, төсөвт байгууллагуудын орлого 2.5 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс давж нийслэлийн нийт орлого төлөвлөгөөнөөс 9.2 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна. Орхон аймгийн цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын албан татварын орлого 1.5 тэрбум, газрын төлбөрийн орлого 1.8 тэрбум, орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийн орлого 0.5 тэрбум, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 0.2 тэрбум төгрөгөөр тус тус дутсан нь тус аймгийн орлого 1.3 тэрбум төгрөгөөр дутахад нөлөөлсөн байна. Өмнөговь аймгийн ус рашааны нөөц ашигласаны төлбөр орлого 2.3 тэрбум, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 5.5 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс давж аймгийн нийт орлого 6.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.
- Хүний хөгжлийн санд 392.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөгөөнөөс 1.2 хувиар буюу 4.9 тэрбум төгрөгөөр дутуу байна. Энэ нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 11.6 төгрөгөөр дутуу биелсэнтэй холбоотой байна.
- Нийгмийн даатгалын сангийн орлого 1,270.5 тэрбум төгрөгт хүрч, 2.5 хувиар буюу 30.4 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс давж төвлөрсөн байна. Тус санд улсын төсвөөс 264.6 тэрбум төгрөгийн татаасыг олгоод байна.

Б. Нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилт:

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2013 оны 12 дугаар сарын байдлаар 6,800.9 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 6,178.0 тэрбум төгрөгийн буюу 90.8 хувийн, улсын төсвийн зарлага 5,165.6 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 4,731.2 тэрбум төгрөгийн буюу 91.6 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийг орлогын төрлөөр авч үзвэл:

ТӨСВИЙН ЗАРЛАГА	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны лөн үеий	жилийн Төлөв.	2013 ОНЫ Төлөв.	12 САР Гүйцэт.	ХУВЬ (4 : 3)	ЗӨРҮҮ (4 : 2) (4 - 3)	
	1	2	3	4	5	6	7
	(Тэрбум төгрөг)						
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,993.8	6,800.9	6,800.9	6,178.0	90.8	90.8	-622.9
УРСГАЛ ЗАРДАЛ	4,404.1	4,809.9	4,809.9	4,559.3	94.8	94.8	-250.5
Бараа, үйлчилгээний зардал	2,052.4	2,537.3	2,537.3	2,393.6	94.3	94.3	-143.7
Цалин хөлс	1,197.2	1,418.6	1,418.6	1,400.0	98.7	98.7	-18.6
Нийгмийн даатгалын шимтгэл	112.8	135.5	135.5	131.3	96.9	96.9	-4.2
Бараа, үйлчилгээний бусад зардал	855.3	1,118.7	1,118.7	993.6	88.8	88.8	-125.1
Зээлийн үйлчилгээний төлбөр	125.9	313.8	313.8	270.5	86.2	86.2	-43.3
Татаас ба шилжүүлэг	2,225.8	1,958.8	1,958.8	1,895.3	96.8	96.8	-63.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,525.4	1,901.3	1,901.3	1,447.3	76.1	76.1	-454.0
Дотоод эх үүсвэрээр:	1,427.9	1,687.5	1,687.5	1,202.8	71.3	71.3	-484.7
Гадаад эх үүсвэрээр	97.5	213.8	213.8	244.5	114.4	114.4	30.7
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	64.3	89.7	89.7	171.3	191.0	191.0	81.6
УРСГАЛ ТЭНЦЭЛ	423.9	1,571.5	1,571.5	1,319.7	84.0	84.0	-251.9
НИЙТ ТЭНЦЭЛ	-1,130.7	-416.7	-416.7	-297.3	71.3	71.3	119.5

- Улсын төсвийн халамжийн сангаас алдар цолтой ахмад дайчдын тэтгэмжид 5.8 тэрбум, алдарт эхийн одонтой эхчүүдэд 30.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна. Хотын нийтийн тээврийн татаас 53.2 тэрбум, эрчим хүч, дулааны алдагдлын татаас 32.7 тэрбум, улаан буудай, махны татаас 24.2 тэрбум, засгийн газрын нөөц хөрөнгийн зардал 19.8 тэрбум, их дээд сургууль коллежийн оюутны тэтгэлэг 105.7 тэрбум, хөрөнгийн зардал 1,069.6 тэрбум төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй байна. Улсын төсвөөс 155.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 784.0 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, 187.5 тэрбум төгрөгийн ОН-ийн хөгжлийн сангийн шилжүүлгийг тус тус орон нутагт олгоод байна.
- Орон нутгийн төсвийн зарлага 1,765.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 89.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Орон нутгаас улсын төсөвт 24.2 тэрбум төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.
- Хүний хөгжил сангийн зарлага 277.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 98.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус сангаас хүүхдэд олгож байгаа бэлэн мөнгөний санхүүжилтээр 229.0 тэрбум, иргэн бүрт олгох 21000 төгрөгийн санхүүжилтээр 27.5 тэрбум төгрөгийг тус тус олгоод байна.
- Нийгмийн даатгалын сангийн төлөвлөгдсөн зардал 98.7 хувийн буюу 1,054.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Тус сангаас улсын эмнэлгүүдэд 89.4 тэрбум төгрөгийг татаасыг олгосон байна.

Эргэж төлөгдөх цэвэр зээл :

Улсын төсвөөс 0.7 тэрбум төгрөгийн зээлийг олгож, 19.9 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийг барагдуулсан байна. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр эхний 12 сарын байдлаар Дорноговь аймгийн дулаан хангамжыг сайжруулах болон нүүрсний

нөөцийг бүрдүүлэхэд зориулж 0.7 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. Гадаадын зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтөөр 21.1 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрсөн байна. Хөгжлийн банкны дүрмийн санг нэмэгдүүлэх 50.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрэн олгосон байна.

Төсвийн тэнцэл:

Тайлант хугацаанд гадаад зээлийн үндсэн төлбөрт 94.6 тэрбум, дотоод зээлийн үндсэн төлбөрт 3.8 тэрбум, Засгийн газрын богино хугацаат бондын үндсэн төлбөрт 1,494.5 тэрбум, урт хугацаат бондын үндсэн төлбөрт 344.2 тэрбум төгрөгийг тус тус төлж, 308.5 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл авч, урд онуудад орсон 76.5 тэрбум төгрөгийн урьдчилгаа орлого орлогод тооцогдож, Засгийн газрын 1,563.0 тэрбум төгрөгийн богино хугацаат, 1,085.7 тэрбум төгрөгийн урт хугацаат бондыг тус тус арилжаалсан гүйцэтгэлтэй байна. Тайлант үед Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 1,319.7 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 297.3 тэрбум төгрөгийн алдагдалтай, улсын төсвийн урсгал тэнцэл 381.2 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 745.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

-----oOo-----